



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 521

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн  
төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүнийг  
чөлөөлөх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 2.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Зам, тээврийн хөгжлийн яамны 2018 оны 03/5126 дугаар албан бичгээр ирүүлсэн саналын дагуу “Хархорин АЗЗА”, “Өвөрхангай АЗЗА”, “Архангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн С.Дорждагвыг 2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

2.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА